



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2023/160/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга,
Булган аймаг	тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
2023 он	Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@auditgov.mn
	Аудитын менежер: Ж.Энхцоодол
	Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
	Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
	Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.09 № 34  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХУТАГ-ӨНДӨР СУМ ДАХЬ СУМ  
ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА  
Ш.ДАВААХҮҮ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сум дахь сум дундын ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хутаг-Өндөр сум дахь сум дундын Ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д заасан хязгаарлалтад хамрагдаагүй.

Хутаг-Өндөр сум дахь сум дундын ойн ангийн 1 хөтөлбөр, 1 арга хэмжээний хүрээнд нийт 71,096.6 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 64,028.0 мянган төгрөгийг зарцуулж хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 90 хувьтай байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

006020035

Хутаг-Өндөр суман дахь Ойн ангийн шууд захирагч нь 2022 онд Байгаль орчны газрын даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 88 хувийн биелэлтэйгээр тайлагнасан байна.

#### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,452,420.02</b>	<b>18,759,925.02</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	4,995,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	4,995,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	17,452,420.02	13,764,925.02
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	6,825,529.02	6,825,529.02
35110	Тусгай зориулалттай материал	6,825,529.02	6,825,529.02
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	10,626,891.00	6,939,396.00
35420	Аж ахуйн материал	4,541,935.00	854,440.00
35450	Барилгын засварын материал	5,964,956.00	5,964,956.00
35470	Бусад хангамжийн материал	120,000.00	120,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,850,402.85</b>	<b>89,424,495.61</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	11,850,402.85	89,424,495.61
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	11,674,402.77	89,264,995.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,511,200.00	2,511,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-669,653.50	-690,580.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,725,000.00	81,695,073.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-700,520.85	-10,291,466.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,334,000.00	19,549,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,334,000.00	-4,459,000.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,338,213.66	14,338,213.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,859,836.54	-13,970,444.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,330,000.00	2,330,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-1,747,500.03
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	176,000.08	159,500.11
39301	Програм хангамж	220,000.00	220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-43,999.92	-60,499.89
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>29,302,822.87</b>	<b>108,184,420.63</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>29,302,822.87</b>	<b>108,184,420.63</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	29,302,822.87	<b>108,184,420.63</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,750,000.02	1,750,000.02
51101	Өмч: - төрийн	1,750,000.02	1,750,000.02
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	27,552,822.85	106,434,420.61
51210	Өмнөх үеийн үр дүн	27,552,822.85	27,552,822.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	78,881,597.76
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>29,302,822.87</b>	<b>108,184,420.63</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>109,165,008.00</b>	<b>171,667,872.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>38,543,913.00</b>	<b>119,621,272.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	38,543,913.00	119,621,272.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,543,913.00	119,621,272.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,488,913.00	27,661,199.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	9,990,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,055,000.00	81,970,073.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>70,621,095.00</b>	<b>52,046,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	66,933,600.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	66,933,600.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,687,495.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,687,495.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	52,046,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	52,046,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>103,212,638.87</b>	<b>92,786,274.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>103,212,638.87</b>	<b>92,786,274.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	60,871,011.71	76,792,317.11
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	42,214,853.67	41,515,182.21
210101	Үндсэн цалин	29,165,218.18	36,227,129.05
210102	Нэмэгдэл	9,190,338.71	3,123,823.00
210104	Урамшуулал	00.00	1,361,484.16
210105	Гэрээт ажлын хөлс	3,859,296.78	802,746.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,482,532.63	5,229,809.66
210201	Тэтгэврийн даатгал	3,795,136.28	3,657,146.00
210202	Тэтгэмжийн даатгал	422,858.87	366,422.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	334,047.42	322,538.91
210204	Ажилгүйдлийн даатгал	96,800.00	76,955.43
210205	Эрүүл мэндийн даатгал	833,690.06	806,746.42
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,555,386.08	5,059,500.00
210401	Бичиг хэрэг	388,400.00	560,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	4,149,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	350,000.00
210408	Бараа материал акалсны зардал	2,866,986.08	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	650,000.00	450,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	650,000.00	450,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	675,000.00	3,649,750.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	500,000.00
210604	Урсгал засвар	675,000.00	3,149,750.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	593,200.00	798,000.00
210702	Дотоод албан томилолт	593,200.00	798,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	176,899.54	2,622,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,163,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	38,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,500.00	45,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,999.54	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	375,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,523,139.79	17,467,575.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	4,656,095.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,923,139.79	12,611,480.24
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	42,341,627.16	20,988,957.13
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	30,860,700.00	300,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,560,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	11,480,927.16	15,693,957.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,480,927.16	15,693,957.13
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>5,952,369.13</b>	<b>78,881,597.76</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>5,952,369.13</b>	<b>78,881,597.76</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>100,110,008.00</b>	<b>89,697,799.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>29,488,913.00</b>	<b>37,651,199.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	29,488,913.00	37,651,199.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	29,488,913.00	37,651,199.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,488,913.00	27,661,199.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	9,990,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>70,621,095.00</b>	<b>52,046,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	66,933,600.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	66,933,600.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,687,495.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,687,495.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	52,046,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	52,046,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>100,110,008.00</b>	<b>81,482,299.00</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>100,110,008.00</b>	<b>81,482,299.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>57,768,380.84</b>	<b>60,493,341.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	42,214,853.67	41,515,182.21
210101	Үндсэн цалин	29,165,218.18	35,999,923.20
210102	Нэмэгдэл	9,190,338.71	3,351,028.85
210104	Урамшуулал	00.00	1,361,484.16
210105	Гэрээт ажлын хөлс	3,859,296.78	802,746.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,482,532.63	5,229,809.66
210201	Тэтгэврийн даатгал	3,795,136.28	3,619,846.00
210202	Тэтгэмжийн даатгал	422,858.87	403,722.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	334,047.42	322,538.91
210204	Ажилгүйдлийн даатгал	96,800.00	76,955.43
210205	Эрүүл мэндийн даатгал	833,690.06	806,746.42
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,688,400.00	5,099,100.00
210401	Бичиг хэрэг	388,400.00	599,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	4,149,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	350,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	650,000.00	450,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	650,000.00	450,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	675,000.00	3,649,750.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	500,000.00
210604	Урсгал засвар	675,000.00	3,149,750.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	593,200.00	798,000.00
210702	Дотоод албан томилот	593,200.00	798,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	176,899.54	2,582,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,124,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	38,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,500.00	45,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,999.54	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	375,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,287,495.00	1,168,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,087,495.00	968,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	200,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,341,627.16</b>	<b>20,988,957.13</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	30,860,700.00	300,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,560,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	11,480,927.16	20,688,957.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,480,927.16	20,688,957.13
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>8,215,500.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>8,215,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>8,215,500.00</b>

<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	8,215,500.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	7,615,500.00
223001	Бусад хөрөнгө	00.00	600,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-8,215,500.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,750,000.02</b>	<b>00.00</b>	<b>21,192,236.38</b>	<b>00.00</b>	22,942,236.40
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>1,750,000.02</b>	<b>00.00</b>	<b>21,192,236.38</b>	<b>00.00</b>	22,942,236.40
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,360,586.47	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,750,000.02</b>	<b>00.00</b>	<b>27,552,822.85</b>	<b>00.00</b>	29,302,822.87
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	<b>1,750,000.02</b>	<b>00.00</b>	<b>27,552,822.85</b>	<b>00.00</b>	29,302,822.87
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>1,750,000.02</b>	<b>00.00</b>	<b>27,552,822.85</b>	<b>00.00</b>	29,302,822.87
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	78,881,597.76	00.00	78,881,597.76
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,750,000.02</b>	<b>00.00</b>	<b>106,434,420.61</b>	<b>00.00</b>	108,184,420.63

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	71,096,600.00	64,028,091.87
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	71,096,600.00	64,028,091.87
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	70,796,600.00	63,728,091.87
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	45,999,200.00	39,965,182.21
210101	Үндсэн цалин	35,768,000.00	34,449,923.20
210102	Нэмэгдэл	6,123,200.00	3,351,028.85
210104	Урамшуулал	00.00	1,361,484.16
210105	Гэрээт ажлын хөлс	4,108,000.00	802,746.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,949,400.00	5,039,159.66
210201	Тэтгэврийн даатгал	4,056,900.00	3,429,196.00

210202	Тэтгэмжийн даатгал	481,000.00	403,722.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	368,000.00	322,538.91
210204	Ажилгүйдлийн даатгал	92,000.00	76,955.43
210205	Эрүүл мэндийн даатгал	951,500.00	806,746.42
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,700,000.00</b>	<b>4,699,600.00</b>
210401	Бичиг хэрэг	600,000.00	599,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,750,000.00	3,750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	350,000.00	350,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>450,000.00</b>	<b>450,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	450,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,673,000.00</b>	<b>3,649,750.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,020,900.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	3,152,100.00	3,149,750.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>300,000.00</b>	<b>246,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	300,000.00	246,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,525,000.00</b>	<b>1,457,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	999,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	38,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,500.00	45,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	375,000.00	375,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>200000.00</b>	<b>200000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	200,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>300,000.00</b>	<b>300,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	7,420,500.00
223001	Бусад хөрөнгө	00.00	600,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>71,096,600.00</b>	<b>79,707,799.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>52,046,600.00</b>	<b>52,046,600.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	52,046,600.00	52,046,600.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>19,050,000.00</b>	<b>27,661,199.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,005,000.00	27,661,199.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>05.50</b>	<b>05.50</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	04.50	04.50

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>00.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,687,495.00</b>	<b>4,980,750.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		4,980,750.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		1,550,000.00
210101	Үндсэн цалин		1,550,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		190,650.00
210201	Тэтгэврийн даатгал		190,650.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		399,500.00
210402	Тээвэр, шатахуун		399,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		195,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		195,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		552,000.00
210702	Дотоод албан томилолт		552,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		1,125,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,125,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,687,495.00	968,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,687,495.00	968,600.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		5,009,250.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3687495.00	9900000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,687,495.00	9,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,687,495.00	9,990,000.00

### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн анги нь орон нутгийн хэмжээнд ойн нөөцийг судлах түүнийг хамгаалан, зохистой ашиглах, нөхөн сэргээлтийн бодлогыг хэрэгжүүлэх, ойн талаар харилцаанд оролцогч талуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, ойн талаар мэдээллээр төр захиргааны байгууллага иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хангах үүрэгтэй орон нутгийн эрх бүхий байгууллага болж үйл ажиллагаа явуулна гэж зорилгоо тодорхойлжээ.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд 2022 онд хариуцаж буй ойн сан бүхий сумуудын ойн менежментийг сайжруулах, Ойгоос мод мод бэлтгэх эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн ойн нөхөн сэргээлтийг сайжруулах, Ойн ангийн ажилчдын ур чадварыг сайжруулах хөрвөн ажиллах чадвар эзэмшүүлэхэд оршино гэж зорилтоо тодорхойлжээ.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.**

Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн анги нь Ойн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын мөрдлөг болгон мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт нь 2020 оны 12 сарын 22-ны өдрийн 174 дугаар тушаалаар шинэчлэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2 жил дутам хяналт шалгалт хийдэг мөн аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс 2022 оны 2 дугаар сард санхүүгийн үйл ажиллагаанд заавар зөвлөгөө өгч ажилласан байна.

Иймд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр суман дахь Ойн анги нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Булган аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 дүгээр захирамжаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн санхүүгийн тайлангийн бүртгэл хөтөлдөг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хутаг-өндөр суман дахь сум дундын ойн анги нь 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 78,881.6 мянган төгрөгөөр буюу 269.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	4,995.00	4,995.00
Бараа материал	17,452.40	13,764.90	(3,687.50)
Үндсэн хөрөнгө	11,850.40	89,424.50	77,574.10
Нийт хөрөнгө	29,302.80	108,184.40	78,881.60
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	29,302.80	108,184.40	78,881.60
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	29,302.80	108,184.40	78,881.60

Дээрх хүснэгтээс харахад авлага дансны үлдэгдэл 4,995.0 мянган төгрөг болж нэмэгдсэн нь аймгийн Байгаль хамгаалах сангаас 9,990.0 мянган төгрөгийн арчилгааны огтлолын нэмэлт санхүүжилтийг дутуу зарцуулж төсвөөс авах санхүүжилтийн авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 13,764.4 мянган төгрөг болж 3,687.5 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуй материалын өмнөх оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 78,881.6 мянган төгрөгөөр өссөн нь Хутаг-Өндөр сумын ЗДТГ-аас үнэ төлбөргүй 7,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж шилжүүлэн авсан, Байгаль орчны яамнаас 74,970.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг шилжүүлэн авсан, өөрийн хөрөнгөөр 8,215.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 40,046.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжих

19,050.0 мянган төгрөгөөр нийт зарлагыг 59,096.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналд өөрчлөлт оруулаагүй баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 12,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 52,046.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 19,050.0 мянган төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 52,046.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 27,661.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 64,028.1 мянган төгрөг буюу 90 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 7,068.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	71,096.0	64,028.0	4,785.0	90%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны байгууллагаас арчилгааны огтлолын 9,990.0 мянган төгрөгийн орлогыг хүлээн авч гүйцэтгэлтэйгээр цалингийн зардалд 1,740.6, шатахууны зардалд 399.5, багаж хэрэгслийн 195.0, дотоод томилолтын зардалд 552.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 1,125.0, бараа үйлчилгээний бусад зардалд 968.6 нийт 4,980.7 мянган төгрөгийг зарцуулж 4,995.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэн авлагаар тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хутаг-Өндөр суман дахь сум дундын ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дансны ангилал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сум дахь сум дундын ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр бусд буюу тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 70,496.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,057.5 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Санхүүгийн албаны даргын зөвлөгөөнд сууж хуульд заасан хориглосон заалтад зардал зарцуулаагүй байна.

Мөн дээрх хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор цалингийн зардлыг 6,034.0 мянган төгрөг, томилолтын зардлыг 54.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 67.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хутаг-Өндөр сум дахь Ойн анги шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 3 удаагийн нийт 22,529.7 мянган төгрөгийн орлогын мэдээлэл, 6.4.8-д заасан 5 удаагийн 2,500.0 мянган төгрөгийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж, 6.4.5-д заасны дагуу цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгийн 2 удаагийн 21,464.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 зугаар зүйлийн 6.4-д “Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4-д заасан заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажиллаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 29,600.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэнг бүрэн хэрэгжүүлэн хариуг 2022 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 12 тоот албан бичгээр хариу ирүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0			
Албан шаардлага	0	0			
Зөвлөмж	2	29,600.0	2	2	100
Нийт дүн	2	29,600.0	2	2	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 1,089.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 1,089.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож хүргүүллээ.

### **5.1 Төлбөрийн акт**

Анхан шатны баримтгүй 335.2 мянган төгрөгийг цалингийн зардлаас, 504.0 мянган төгрөгийг, томилолтын зардлаас 250.0 мянган төгрөгийг шатахууны зардлаас тус тус зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 -д заасан заалтыг, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд нийт 1089.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Дээрх төлбөрийн актины биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/						
							Үүнээс		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>Дүн</b>	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Анхан шатны баримтгүй төгрөгийг цалингийн зардлаас, 504.0 мянган төгрөгийг, томилолтын зардлаас 250.0 мянган төгрөгийг шатахууны зардлаас тус тус зарцуулсан	1	1,089.2	1	1,089.2									
<b>Дүн</b>	1	1,089.2	1	1,089.2	0	0	0	0	0		0		0

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>							
<b>Дүн</b>	0	0	0	0	0	0	0	0
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй	1						1	
<b>Дүн</b>	1						1	
<b>Нийт дүн</b>	1						1	